

**ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ИТХ-ЫН 2023 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН
ТОГТООЛЫН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ
ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

2023.06.27

Дархан-Уул аймаг

Дархан-Уул аймгийн ИТХ-ын 2023 оны хагас жилийн нийт 20 тогтоолын биелэлтийг хяналтад авч хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд тогтоолын биелэлт **91.0%** буюу **4.55** онооны үнэлгээтэй байна.

ҮНЭЛГЭЭНИЙ ТАНИЛЦУУЛГА

№	Биелэлт	Бүгд	Үүнээс								
			ТЗУХ	ГБХЗХГ	Татварын хэлтэс	БОАЖГ	ОНОГ	ДХСАХ	ГХХБГ	ЗАА	ХБГХОХ
Хяналтад авсан тогтоолын тоо		20	1	2	2	1	7	1	1	2	3
Үүнээс:	Үр дүнтэй буюу 100%	16	1	2	1	1	7	1	1	1	1
	Тодорхой үр дүнд хүрсэн 90%										
	Тодорхой үр дүнд хүрсэн 70%	1								1	
	Эрчимжүүлэх шаардлагатай 50%	3			1						2
	Эрчимжүүлэх шаардлагатай 30%										
	Үр дүнгүй буюу 0%										
Хэрэгжилтийн хувь		91.0%	100%	100%	75.0%	100%	100%	100%	100%	85.0%	66.67%
Хэрэгжилтийн оноо		4.55 оноо	5.0	5.0	3.75	5.0	5.0	5.0	5.0	4.25	3.33

ТОДОРХОЙ ҮР ДҮНД ХҮРСЭН БУЮУ 70%-ТАЙ ТОГТООЛЫН ХЭРЭГЖИЛТ


№	Тогтоолын нөхцөл	Тэргүүлэгчдийн тогтоол	Тогтоолын заалт	Хариуцах хэлтэс	Хэрэгжүүлэх хугацаа	Хэрэгжилтийн явц, гарсан үр нөлөө	Үнэлгээ
1	10	Нийтийн эзэмшлийн газар, барилга, байгууламж дээр зар сурталчилгаа байрлуулах зөвшөөрөл олгох журам 2023.02.10	Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, жил бүр тайлагнаж ажиллахыг аймгийн Засаг дарга (Б.Азжаргал)-д үүрэг болгосугай	ЗАА	2023 он	Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 8 дахь удаагийн сонгуулийн ээлжит 15 дугаар хуралдаанаар /2023.02.10/ “Нийтийн эзэмшлийн газар, барилга, байгууламж дээр зар сурталчилгаа байрлуулах зөвшөөрөл олгох журам батлах тухай” тогтоолыг хэлэлцүүлэн батлуулсан. Баталсан тогтоолыг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын ажлын албанаас Хууль зүй, дотоод хэргийн яаманд /2023.02.13/ албан бичгээр хүргүүлсэн.	70%

ХЭРЭГЖИХ ШАТАНД БУЮУ 50%-ТАЙ ТОГТООЛЫН ХЭРЭГЖИЛТ

№	Тогтоолын дугаар	Тэргүүлэгчдийн тогтоол	Тогтоолын заалт	Хариуцах хэлтэс	Хэрэгжүүлэх хугацаа	Хэрэгжилтийн явц, гарсан үр нөлөө	Үнэлгээ
1	8	Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө батлах тухай 2023.02.10	Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж ажиллахыг аймгийн Засаг дарга /Б.Азжаргал/-д үүрэг болгосугай.	ХБТХОХ	2023 он	<p>1. Дархан сумын 12 дугаар баг, 7, 14 дүгээр хороолол, 15 дугаар багт байрлах 29, 30 дугаар хорооллын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулах зураг төслийн ажлын даалгаврыг боловсруулан батлуулсан. Төсөвт суугдаагүй байна.</p> <p>Дархан сумын 13-р багт Залуус-1 хороолол 102га талбайд, 15-р багт Залуус-2 хороололд 23га талбайд хорооллуудыг төлөвлөн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг Инженер геодези ХХК гүйцэтгэж, аймгийн ИТХ-ын 2023.02.10-ны өдрийн 08 дугаар тогтоолоор батлуулсан.</p> <p>Үр дүн: Залуус 1,2 төслийн хүрээнд 127 га талбайд хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулагдаж байна. Дэд бүтэц татах ажлын гүйцэтгэгч шалгарсан.</p> <p>2. Дархан сумын 4, 5, 6, 7, 8 дугаар багийн нутагт 5 байршилд нийт 136 га талбайд дахин төлөвлөлтийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө хийлгэхээр ажлын даалгавар боловсруулж батлуулсан. Ерөнхий төлөвлөгөөний гүйцэтгэгчээр "Инженер геодези" ХХК шалгарч гэрээ байгуулсан. Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажил 70 хувийн гүйцэтгэлтэй, 2023 оны 10-р сард захиалагч байгууллагад хүлээлгэн өгнө.</p> <p>Үр дүн: 5 байршилд нийт 136 га талбайд дахин төлөвлөлтийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулж байна.</p>	50%
2	9	“Нээлтэй Дархан” хөтөлбөр батлах тухай 2023.02.10	“Нээлтэй Дархан” хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг баталж, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг тухайн жилийн төсөвт тусгаж, хөтөлбөрийн биелэлтийн явцыг жил бүр аймгийн	ХБТХОХ	2023 он	<p>Улаанбаатар хотоос хөдөө орон нутагт шилжин суурьших иргэдийн ажиллаж, амьдрах нөхцөл боломжийг нэмэгдүүлэх, орон нутагт үйл ажиллагаа явуулах аж ахуйн нэгжийг дэмжих цогц арга хэмжээний санал боловсруулах дэд ажлын хэсгийг аймгийн Засаг даргын 2022 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн Дугаар 01-А/298 захирамжаар 21 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан. Улаанбаатар хотоос орон нутагт шилжин суурьших иргэд, аж ахуйн нэгж байгууллагыг дэмжих арга хэмжээний санал авах хэлэлцүүлэг, зөвлөгөөнийг 2023 оны 01 дүгээр сарын 05-ны өдөр зохион байгуулсан.</p> <p>“Нээлтэй Дархан” хөтөлбөрийн төслийг боловсруулж Засаг даргын дэргэдэх Зөвлөлийн хурал, аймгийн</p>	50%

			иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулахыг аймгийн Засаг дарга /Б.Азжаргал/-д даалгасугай.			ИТХ-ийн Зөвлөлөөр хэлэлцүүлж, 2023 оны 01 дүгээр сарын 26-нд хурлын хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулсан бол аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 09 дугаарт тогтоолоор “Нээлттэй Дархан” хөтөлбөрийг тодотгон баталсан. Улаанбаатар хотод 2023 оны 03 дугаар сарын 10-н өдөр зохион байгуулсан Хот хөдөөгийн сэргэлт формд Дархан-Уул аймаг оролцож Дархан-Уул, Орхон, Булган, Хөвсгөл, Сэлэнгэ, Архангай, Төв аймгуудыг төлөөлж илтгэл танилцуулга хийсэн. Улаанбаатар хотоос Дархан-Уул аймагт 2023-2024 онд нийт 20.0 мянган иргэн ирэхээр тооцоо гарсан бөгөөд 5000 өрх айл буюу 3200 хүүхэд сургуулийн өмнөх боловсролд, 4800 хүүхэд ерөнхий боловсролын сургуульд, 2000 оюутан, 8400 хөдөлмөрийн насны иргэн, 1600 ахмад настан ирэх тооцоо хийгдсэн. 2020-2023 онд Дархан-Уул аймагт 1159 иргэн ирсэн бол 2478 иргэн шилжсэн байна. Үр дүн: Нээлттэй Дархан хөтөлбөр батлагдсан. 21 хүний бүрэлдэхүүнтэй дэд ажлын хэсэг байгуулагдсан. Улсын төсвөөс 200.0 сая төгрөг шийдвэрлэсэн	
3	12	Бичил худалдаа, ажил, үйлчилгээний орлогын албан татварын хувь хэмжээг тогтоох тухай 2023.02.10	Тогтоолыг иргэд олон нийтэд сурталчлах, татварын бааз суурийг нэмэгдүүлж, тэгш хамруулах ажлыг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (Б.Азжаргал)-д үүрэг болгосугай.	Татварын хэлтэс	2023 он	Тогтоолыг татвар төлөгчдөд сурталчлан эхний 6-н сарын байдлаар Аймаг, сум дотор болон хот хооронд тээврийн үйлчилгээ эрхэлж буй давхардсан тоогоор 267 татвар төлөгчтэй татварын тооцоотой хийж 13169,6 мянган төгрөгийн татварыг сумын төсөвт төвлөрүүлсэн байна. /Бичил худалдаа ажил үйлчилгээ эрхлэгчдийн татварын бааз суурийг өргөтгөсөн талаар хэрэгжилтэд тусгагдаагүй. /	50%

Тогтоолын хэрэгжилт ирүүлэх Хэлтэс, агентлаг



ҮНЭЛГЭЭГ ХЯНАСАН:

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН
ДАРГА П. БАЯРСАЙХАН

ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ
МЭРГЭЖИЛТЭН Г. ГЭРЭЛМАА